



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/149

Баян-Өндөр сум

Хариуцлагатай эргүүл, жижүүрийг  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.10 дахь заалт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 22 дугаар “Ажил, амралтын цагийг зохицуулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэстний уламжлалт Цагаан сарын баярын өдрүүдэд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр хүртэл хугацаанд ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралтаар баталж, томилсугай.

2. Дээрх хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, хяналтын пост, эргүүлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Цагдаагийн газар (А.Лхагвадорж)-т, галын аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Ш.Баасандорж)-т, ус, дулаан, цахилгаан эрчим хүчний хэвийн найдвартай байдлыг хангаж, доголдохоос урьдчилан сэргийлж ажиллахыг Хотын захирагчийн алба (Б.Одгэрэл), “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК (Г.Эрдэнэбат), Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК (Б.Бат-Эрдэнэ), Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК (Б.Эрдэнэцогт)-д, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээг тасралтгүй шуурхай хүргэж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ц.Мөнхцэцэг), Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Ц.Наран-Эрдэнэ)-д, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Даваадорж)-т, хот хоорондын болон нийтийн тээврийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Авто тээврийн төв (С.Гарьдпүрэв)-д тус тус үүрэг болгосугай.

3. Хавсралтад заасан агентлаг, хэлтэс, албадын дарга нар томилогдсон хугацаандаа хариуцлагатай ажиллах, тухайн байгууллага дээрээ хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Баян-Өндөр

D:\zahiramj\A-4.doc  
6126010547

Жаргалант сумдын Засаг дарга, төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, эрхлэгч нарт тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (М.Мөнхбаяр), Цагдаагийн газар (А.Лхагвадорж), Онцгой байдлын газар (Ш.Баасандорж), Хотын захирагчийн алба (Б.Одгэрэл)-нд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

Аймгийн Засаг даргын 2026 оны  
 4/17/9 дугаар сарын ...-ны өдрийн  
 дугаар захирамжийн хавсралт

### ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛИЙН ХУВААРЬ

№	Хариуцлагатай эргүүл, жижүүрийн нэрс	Ажил, албан тушаал	Ажиллах өдөр, цаг
1	1. Л.Уртнаст	Мал эмнэлгийн газрын дарга	2026.02.17-ны өдрийн 12.00-18.00
	2. С.Даваадорж	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	2026.02.17-ны өдрийн 18.00-24.00
	3. Х.Одбаяр	Цагдаагийн газрын ЗЦТ-ийн дарга, дэд хурандаа	2026.02.17-ны өдөр
2	4. А.Ганбаяр	Шүүхийн шинжилгээний хэлтсийн дарга	2026.02.18-ны өдрийн 12.00-18.00
	5. Г.Эрдэнэбат	"Эрдэнэт-Ус ДТС" ОНӨХК-ийн захирал	2026.02.18-ны өдрийн 18.00-24.00
	6. Ч.Мөнхбат	Цагдаагийн газрын ГЦХ-ийн дарга, хурандаа	2026.02.18-ны өдөр
3	7. Р.Ууганбаяр	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга	2026.02.19-ний өдрийн 12.00-18.00
	8. Б.Баасансүрэн	Хот тохижуулах газрын дарга	2026.02.19-ний өдрийн 18.00-24.00
	9. Б.Билэгжүгдэр	Цагдаагийн газрын НХЖХОНАБХТ-ийн дарга, дэд хурандаа	2026.02.19-ний өдөр
4	10. М.Баянзул	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2026.02.20-ны өдрийн 12.00-18.00
	11. Б.Цэвээнсүрэн	Татварын газрын дарга	2026.02.20-ны өдрийн 18.00-24.00
	12. С.Түвшинжаргал	Дотоодын цэргийн 821 дүгээр тусгай салбарын сургалт, хүний нөөц хариуцсан орлогч дарга, хошууч	2026.02.20-ны өдөр
5	13. Д.Сайзмаа	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга	2026.02.21-ний өдрийн 12.00-18.00
	14. С.Отгонбаатар	УЦУОШТ-ийн дарга	2026.02.21-ний өдрийн 18.00-24.00
	15. Б.Билэгсайхан	Цагдаагийн газрын НХЖХОНАБХТ-ийн ХЦХ-ийн дарга, дэд хурандаа	2026.02.21-ний өдөр
6	16. Ц.Мөнхцэцэг	Эрүүл мэндийн газрын дарга	2026.02.22-ны өдрийн 12.00-18.00
	17. Д.Дэлгэрбаяр	Биеийн тамир, спортын газрын дарга	2026.02.22-ны өдрийн 18.00-24.00
	18. Б.Зоригоо	Цагдаагийн газрын ГХЦХ-ийн ЗЦХ-ийн дарга, хошууч	2026.02.22-ны өдөр

Тайлбар: Томилогдсон хариуцлагатай эргүүл, жижүүр нь тухайн өдөр Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын зэрэг жижүүрээс яаралтай тусламж, дуудлагын болон цаг үеийн нөхцөл байдлын

мэдээллийг авах, шаардлагатай зарим онцгой объектуудын (“Дулааны цахилгаан станц”, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ” ОНӨХК, ШТС, банк зэрэг) харуул хамгаалалт болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шалгасан тухай тэмдэглэл, мэдээллийг Нутгийн удирдлагын ордны зохицуулагч дээр ирж бүртгүүлэн ажиллана.

Хариуцлагатай эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн талаар аймгийн Засаг даргын шуурхай худалдаанд танилцуулна. Мөн Цагдаагийн газраас баярын өдрүүдийн аймгийн хэмжээн дэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээллийг танилцуулна.

\_00\_